



Шинэ эцэг эхчvvд оорсдийн хvvхдийн эрvvл мэндийн толоо байнга санаа тавих хэрэгтэй. Хэдийгээр таны хvvхэд цовоо сэрэглэн, эрvvл харагдаж байгаа хэдий ч хvvхэд бага, эмзэг байдаг учир тэдэнд байнгын халамж, анхаарал шаардлагатай байдаг.

Гэвч та ямар нэгэн зvйл болохгvй байгааг хэрхэн мэдэх вэ? Та оорийн зон совинд итгэж ямар нэгэн зvйл болохгvй байгаа санагдсан вeдээ эмчид хандах хэрэгтэй. Хэд хэдэн гол мэдээллvvдийг дурдвал:

Торх байдал

Хэрэв таны хvvхэд урьдх шигээ тоглож, хогжилтэй хэвээрээ, хоолондоо сайн байвал энэ нь ямар нэгэн овчин эмгэг байхгvйг л илэрхийлж байгаа. Хvvхдийн нус бага зэрэг

гарсан ч сэргэлэн цовоо байгаа бол эрvvл байгаагийн шинж юм. Харин унтаа нойрмог болохын зэрэгцээ нус гарвал ханиад хvрсэний шинж тэмдэг байх болно.

Энгийн бишээр уйлах

Хэрэв таны хvvхэд ямар нэгэн шалтгаангvйгээр гэнэт чангаар уйлвал та тvvнд анхааралаа хандуулах хэрэгтэй ялангуяа саатуулах арга хэмжээ vр дvнгvй удаан уйлсаар байх эсвэл уйлах нь сулбагар байвал энэ нь ямар нэгэн эмгэг vвссэнийг илэрхийлж байгаа юм.

Мон эсрэгээрээ хvvхэд уйлахгvй, тааламжгvй байдалтай, орчиндоо идэвхигvй, сэрэхдээ удаан байвал эмчид vзvvлж зовлогоо аваарай.

Хоолны дуршил

Одроос одорт хvvхэд чинь хэр олсомтгий болж байна. Хэрэв олсож байвал тогтмол хооллох хэрэгтэй. Хэрэв хоол унд муу, арчилгаа сул байвал хvvхэд амархан овчломтгий болдог.

Хэрэв таны хvvхэд хоолондоо дургvй болох, их хэмжээтэй гулгих, баасны онго, шинж байдал нь оорчлогдох зэрэг шинж тэмдэг илэрвэл эмчид хандаарай.

Хэвийн биш баас

Хохоор хооллож буй хvvхэд голдуу зоолон шингэн отгон ялгаруулдаг. Гэвч отгон нь илvvдэл устай байвал магадгvй таны хvvхэд суулгалттай байж болох юм.

Тvvний суулгалтыг анхааралтай ажиглах хэрэгтэй. Хэрэв хvvхэд хохоо, эсвэл хохний сvv орлуулагчаа vргэлжлvvлэн хэвийн хохож байвал шингэн алдалтанд амархан орохгvй. Таны хvvхэд голдуу 6 гаас цоонгvй удаа отгоноор бие засдаг. Тиймээс хvvхэд нойрмог болох баасны тоо нь цоорох, эсвэл хэмээ нь багасах, хатуу, эсвэл отгонд нь цус, салс холилдсон, зоолон цэлцэгнvvр шиг байвал та эмчид хандах хэрэгтэй.

Амьсгалын оорчлолт

Хэрэв амьсгал нь олширч, амьсгалахад хэцvv байгаа бол яаралтай тусламж дуудах хэрэгтэй.

Халууралт

Халууралт нь хvvхдийг овчтэй байгааг харуулж буй боловч зовхон дан халууралт нь тодий л санаа зовох зvйл биш юм. Бага зэргийн халууралттай хvvхэд магадгvй хvнд овдсон, эсвэл ондор халуурч буй хvvхэдийн овчин нь хонгон байж ч болдог. Гэвч 3 сараас дээш насны хvvхдийг 37.5 болон тvvнээс дээш халуурч байвал тvvнийг шалгах шаардлагатай. Хэрэв хvvхэд халуунтай боловч хэвийн байвал тvvнийг одрийн турш оор шинж тэмдэг илрэх эсэхийг ажиглах хэрэгтэй.

Хэрэв танд эргэлзээтэй зvйл байгаа бол та эмчид хандах нь зов юм. Эмчид vзvvлэх нь хэзээ ч буруу алхам биш байдгийг санах хэрэгтэй.

Хvvxдээ ямар вeд эмчид вэvvлэх шаардлагатай вэ?

Мягмар, 17 9 сар 2013 01:08
